

ДеФакто **ТОЙМ**

АМЕРИК,
ОРОСЫН БАТЛАН
ХАМГААЛАХЫН
САЙД НАРЫН
АЙЛЧЛАЛ

VI НҮҮРТ



ДеФакто **НИЙТЛЭЛ**

Д.Жаргалсайхан
Эдийн засагч, нийтлэлч

ҮНДСЭН ХУУЛИЙН
ӨВРЧЛӨЛТ
НАЙМАА БИШ

II НҮҮРТ



ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

Тогтохын Чулуун
Доктор (Ph.D.), МУИС-ийн Тогтвортой
Хөгжлийн Хүрээлэнгийн захирал

МОНГОЛ УЛСЫН
ӨНГӨРСӨН 30 ЖИЛИЙГ
ЦОГЦООР ДҮГНЭХҮЙ

IV НҮҮРТ

WEEKLY

The Defacto Gazette

МЭДЭЭЛНЭ


| ЗОРИГЖУУЛНА

| МЭДЭЛЖҮҮЛНЭ

Пүрэв, 2019.08.15, №6 (110)

УЛС ТӨР, ЭДИЙН ЗАСГИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ, БИЕ ДААСАН,
УЛС ТӨРИЙН НАМААС ХАРААТ БУС, ДОЛОО ХОНОГ ТУТМЫН ГЛОБАЛ СОНИН

www.jargaldefacto.com





Дамбадаржаагийн ЖАРГАЛСАЙХАН

Долоо хоног бүрийн нийтлэл,
<http://jargaldefacto.com/category/23>

ҮНДСЭН ХУУЛИЙН ӨӨРЧЛӨЛТ НАЙМАА БИШ

Үндсэн хууль бол “Нийгмийн гэрээ”. Бид 1992 оны 1-р сарын 13-ны өдөр баталсан гэрээг маргаашнаас нь шинэчлэх тухай ярьсаар найман жилийн дараа өөрчилсөн. Эдүгээ 19 жилийн дараа, дахиад л нэмэлт өөрчлөлт хийх гэж байна.

Үндсэн хууль нь нийгмийн тогтвортой байдлыг хангах зорилготой баримт бичиг учраас дэлхийн улс гүрнүүд Үндсэн хуулиа төдийлөн өөрчлөөд байдаггүй. Тод жишээ бол Европын сэргэн мандалтын ололтуудыг шингээсэн АНУ-ын 200-аад настай Үндсэн хууль. Энэ хууль бол иргэд нь төрөө шударга сонгуулиар сонгох, төр нь иргэнийхээ жам ёсны эрхийг баталгаажуулах зэрэг либераль ардчиллын үндсэн зарчмуудыг илэрхийлсэн учир харьцангуй тогтвортой байдлыг хангадаг. Товчоор, Үндсэн хууль нь ямар төр байхыг мөн ямар үйл ажиллагаа явуулж болох, болохгүйг тодорхойлдог. Монголчуудын Үндсэн хуульдаа оруулж буй шинэчлэл тэгж чадах уу?

НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТИЙН ТӨСЛҮҮД

1. МАН 2016 онд Их Хуралд үнэмлэхүй олонх болмогцоо Үндсэн хуулийг өөрчлөхөө эрчимтэй яриад эхэлсэн. Одоогийн УИХ-ын дарга Г.Занданшатар 2016 онд гишүүн болмогцоо Стэнфордын профессор Фишкинийн “Зөвлөлдөх ардчилал” онолыг монголын хөрсөнд буулгахыг оролдож эхэлсэн. Зөвлөлдөх ардчилал нь шийдвэр гаргахад хүмүүсийг оролцуулах онол бөгөөд шууд ардчилал, төлөөллийн ардчилал хоёрын хослол (хайбрид) юм.

Төдөлгүй Үндсэн хуулийг өөрчлөх талаар иргэд нийтээр хэлэлцүүлэх ажлыг орон даяар өрнүүлсэн. Гэвч энэ хэлэлцүүлэг иргэдийг мэдээлэлжүүлсэн, мэдэлжүүлсэн гэдэг нь эргэлзээ төрүүлдэг. Тайвань маягийн таван салаа мөчир бүхий улс төрийн системийг хавчуулсан хэлэлцүүлэг нь иргэдээс олон саналууд авсан ч, судлаачдын идэвхтэй эсэргүүцэлтэй тулгарч, Гишүүн саналаасаа татгалзав. Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай дээрх хэлэлцүүлгийн дүгнэлт болон Үндсэн хууль судлаачдын саналыг нэгтгэн УИХ-ын гишүүн Д.Лүндээжанцан ахалсан ажлын хэсгээс Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн төслийг гаргав. Энэ төслийг ээлжит бус чуулган зарлаж хэлэлцэхээр боллоо.

2. Гэтэл Ерөнхийлөгч Х.Баттулга Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах өөр нэг төслийг аль нэг халааснаасаа гаргаад ирэх нь тэр. Хэзээ, яаж, хэн судлаад энэхүү төслийг бэлдсэн нь тодорхойгүй. Энэ тухай лавласан залууг Ерөнхийлөгчийн тамгын газрын дарга “яасан том дуутай юм чи” гээд нам болгов.

3. УИХ-д суудалгүй жижиг намуудтай дуу хоолойгоо нэгтгэх болсон МАХН бас нэг төсөл, гэхдээ бүр шинэ Үндсэн хуулийн төсөл бэлджээ. Үүнийгээ тэд Шинэ дээд Үндсэн хууль гэж нэрийдэв. Өөрөөр хэлбэл 1992 оны Үндсэн хуулийг бүтнээр нь өөрчлөх зорилготой гэнэ.

ТОГЛООМЫН ОНОЛ

Энэ өдрүүдэд улс төрчид нэг дэх болон хоёр дахь төслүүдийг эвцүүлэн нэгтгэх ажилд ороод байна. Энэ нь шуудхан хэлэхэд улс төрийн эрх мэдлийн наймаа болж хувирах тийш хандлаа. Заалт бүрээр наймаалцаж чадвал өөрчлөлт батлагдана. Үгүй бол батлагдахгүй нь тэр. УИХ-ын Гишүүд болон Ерөнхийлөгчид тус тусынх нь өргөн барьсан ҮХ-ийн төсөл ашигтай харагдавч эцсийн дүнд нийтэд тэр дундаа иргэдэд бол бүр ч хохиролтой үр дүн гарна. Товчхондоо хэнд ч ашиггүй нөхцөл байдал руу өөрийн мэдэлгүй орчихож байгаа нь “Тоглоомын онол (Game Theory)” лугаа адил.



- Хамгийн гол нь бид судлаачдын олон жил улиг болтол ярьсан хагас ерөнхийлөгчийн тогтолцооноосоо салж, парламентийн тогтолцоогоо бэхжүүлэх зорилго хэрэгжихгүй. Шүүх засаглалын хараат бус байдал үлгэр туульс болно гэсэн үг юм. Ийм маягаар ҮХ-аа шинэчлэх гэж байгаа бол эртхэн больсон нь дээр.

АНХААРАХ ЁСТОЙ АСУУДАЛ

Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулахдаа дараах гол асуудалд анхаарах хэрэгтэй байна. Үүнд:

НЭГ. Үндсэн хуулийн асуудалд хуульчдаас гадна эдийн засаг, улс төр, социологи, антропологи гээд нийгмийн ухааны бусад судлаачдыг идэвхтэй оролцуулах. Учир нь Үндсэн хууль бол тухайн улс орны нийгэм, эдийн засаг, улс төр гээд бүхий л хүрээнд хамаатай.

Жишээ нь өмчийн асуудлыг Үндсэн хуулиар тодорхойлдог. Эдийн засагчид өмчийн асуудлыг нь тодорхойлоход голлох үүрэгтэй оролцох ёстой. Энэ талаар байр сууриа *“Байгалийн баялаг яг хэний өмч вэ”* нийтлэлдээ би дурдсан. Ер нь манай Үндсэн хуулийн талаар хуулийн бус мэргэжилтнүүдийн судалгаа бараг байдаггүй. Хуулийнханд нэг сул тал бий. Тэр нь асуудлыг том зургаар нь харахын оронд техникийн жижиг асуудалд (details) хэт их анхаарч, чухал том асуудлаа харахгүй өнгөрөх нь бий.

ХОЁР. Нэг удаагийн өөрчлөлтөөр бүх асуудлыг шийдэх гэж дайрах нь хохирол авчрах магадлалтай. Тиймээс тухайн цаг үеийн хамгийн чухал, дээд эрэмбийн асуудлаа зөв тодорхойлоод, яг л тэр асуудлаа засахад л төвлөрөх учиртай. Үүнийг Паретогийн 20:80 зарчим гэдэг. Нийт асуудлын 20 хувийг л шийдэхэд үлдсэн 80 хувь дагаад шийдэгддэг. Хэрэв гол биш асуудал руу эхлэж орвол, асуудал шийдэгдэхгүйгээс гадна, 80 хувийн доторх гол биш асуудлууд цааш нь хөтлөөд явна.

Энэ логигоор Үндсэн хуулийн гол өөрчлөлтийг монголчилсон засаглалын гацаанаас гаргах гэж томъёолж болно. Учир нь манай улс төрийн тогтолцоо ерөнхийлөгчийн ч бус, парламентийн ч бус, холимог ч бус, монголчилсон тогтолцоо болчихоод байгаад юм.

Монголчилсон засаглалын гол гацаа гэдэг нь Ерөнхийлөгч гэх субъект төрийн эрх мэдлийн тэнцвэрийг алдуулчихаад байгаа тухай юм. Н.Энхбаярын үед Ерөнхийлөгч Ерөнхий сайдын ажлыг давхар гүйцэтгэж болдог, Ц.Элбэгдоржийн үед Ерөнхийлөгч нь шүүх эрх мэдлийг хэрхэн хянаж, өөрийн эрх ашигт үйлчлүүлж болдгийг тус тус харуулсан. Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж шүүгч нарыг хоморголон халж, буцаагаад томилохдоо 13 шүүгчийг “мартаж” орхисон.

Тэгвэл Ерөнхийлөгч Х.Баттулга нь Үндэсний аюулгүй байдлын зөвлөл нэрээр эрх мэдлээ тэлж байна. Үүний тод жишээ нь саяхан АТГ, Прокурор, Дээд шүүхийн удирдлагуудыг ҮАБЗ-ийн саналыг үндэслэж солих тухай хуулийн өөрчлөлт юм. Ерөнхийлөгч гэх субъект эрх мэдлийн хяналт, тэнцвэрийг устгасаар ирлээ.

ГУРАВ. Уул уурхайн хүчин зүйл. 1992 оны Үндсэн хуулийг хэлэлцэж байхад МУ эдийн засгийн хувьд уул уурхайгаас шууд хамаардаггүй байлаа. Эдүгээ монголын ирээдүй хүссэн ч, эс хүссэн ч уул уурхайгаа хэрхэн авч явахаас де факто, шууд хамаардаг болжээ.

Тиймээс энэ удаагийн өөрчлөлт нь Монгол улсад хариуцлагатай уул уурхай бий болоход эерэгээр нөлөөлөх учиртай. Үгүй бол улс төр, эдийн засгийн байдал маш хүндрэх эрсдэл бий болчихлоо. Жишээ нь одоогийн төслөөр сум, дүүргийн засаг даргыг иргэдээс сонгоно. Энэ нь сумын засаг дарга уул уурхайн төслийг хаах, зогсоох эрхтэй болно гэсэн үг.

Олон хүн суурьшсан газраа хот суурин гэх үү, засаг захиргааны нэгж гэх үү? Засаг захиргааны нэгж гэвэл төрийн үйлчилгээ, улсын төсөвтэй холбоотой асуудал болно. Оршин суугчдын бүтэц гэвэл шал өөр хандлага шаардана. Хот суурин гэвэл дундын асуудлаа шийдэхийн тулд өөрсдийн татвар, хураамжтай, бас бонд гаргах эрхтэй байх ёстой.

Энэ асуудал одоо байгаа Үндсэн хуулинд ч тэр, шинээр өөрчлөх гэж байгаад ч нэг мөр болж чадаагүй байна. Дараа нь дээрх нэгжүүдийн захирагчийг томилох уу, эсвэл сонгох уу гэдэг асуудал яригдана. Хамгийн гол нь сонгосон эсвэл томилсон удирдагч нар чинь нийтийн баялагтай холбоотой ямар эрх мэдэлтэй байх вэ гэдэг чухал. Нийгмийн гэрээ л юм бол бид энэ асуултуудынхаа хариултыг авсныхаа дараа л Үндсэн хуулийн өөрчлөлтөө батлая.

Хамгийн гол нь ҮХ-ийн энэ удаагийн өөрчлөлтөөр монгол ерөнхийлөгчийн тогтолцоотой улс юм уу, эсвэл парламентийн тогтолцоотой юм уу, эсвэл холимог тогтолцоотой юм уу гэдэгт тодорхой хариулт гарч ирэх юм.

2019.08.14



НИЙТЛЭЛ

ТОГТОХЫН ЧУЛУУН

Доктор (Ph.D.), МУИС-ийн Тогтвортой
Хөгжлийн Хүрээлэнгийн захирал

МОНГОЛ УЛСЫН ӨНГӨРСӨН 30 ЖИЛИЙГ ЦОГЦООР ДҮГНЭХҮЙ

Монголчууд маань 1990 оноос хойших өнгөрсөн 30 жилээ эргэж дүгнэн, Үндсэн хуульдаа өөрчлөлт хийх, урт хугацааны бодлого боловсруулах гэж буй энэ мөчид систем судлаач миний бие дэм болох гэж энэ өгүүллийг тэрлэв. Монгол улсын өнгөрсөн 30 жилийн хөгжилд нөлөөлсөн системийн шинжтэй хүчин зүйлүүдийг тодруулах зорилготой.

Нилсон, Григс, Висбек (2016)¹ нар НҮБ-ын тогтвортой хөгжлийн зорилтуудын уялдаа холбоог үнэлж, бодлогын эрэмбэ дараалал тогтоох зорилгоор дэвшүүлсэн аргаар Монгол улсын өнгөрсөн 30 жилийн системийн шинжтэй гол хүчин зүйлүүдийг тодорхойлсон. Тогтвортой хөгжлийн 3 тулгуур нь эдийн засаг, нийгэм болон байгаль орчин гэж үздэг. Гэвч аливаа улсын тогтвортой хөгжлийн асуудлыг судлахдаа улс төр болон соёлын асуудлыг оруулж байж тухайн орны онцлогийг илүү тусгана. Иймээс эдийн засаг, нийгэм, байгаль орчин, улс төр болон соёлын 5, 5 хүчин зүйлсийг сонгон авч, тэдгээрийн хамаарлыг дээрх аргаар үнэлэн, системийн хамгийн нөлөөтэй хүчин зүйлүүдийн үнэлгээг хийлээ.

УЛС ТӨРИЙН ХУВЬД

- үндэсний аюулгүй байдал
- ардчилал
- эрх чөлөө
- олон улсын харилцаа
- авлига хээл хахууль

НИЙГМИЙН ХУВЬД

- Боловсрол
- эрүүл мэнд
- ядуурал
- тэгш бус байдал
- миграци (оюуны алдагдал)

СОЁЛЫН ХУВЬД

- эх оронч үзэл
- мэдээллийн технологи (хэвлэл мэдээлэл)
- нүүдлийн соёл
- барууны соёл
- хотын соёл

ЭДИЙН ЗАСГИЙН ХУВЬД

- эрдэс баялагийн зах зээлийн үнэ
- эдийн засгийн өсөлт
- санхүүгийн алдагдал (өр)
- эдийн засгийн төрөлжилт
- ажилгүйдэл

БАЙГАЛЬ ОРЧНЫ ХУВЬД

- агаарын бохирдол
- газрын доройтол
- ус, биологийн олон хэлбэршил
- эко системийн үйлчилгээ
- ойн доройтол

гэсэн нийт 25 хүчин зүйлийг хамруулан судлав. 2 хүчин зүйлийн хамаарлыг эерэг бол 3 хүртэл, сөрөг бол -3 хүртэл, хамааралгүй бол 0 гэж үнэллээ. Хамгийн өндөр эерэг оноо авсан хүчин зүйл Монгол улсын өнгөрсөн 30 жилийн хөгжилд хамгийн их эерэг нөлөө үзүүлсэн, харин хамгийн бага сөрөг оноо авсан нь хөгжлийг хойш чангаасан гэсэн үг юм.

- Монгол улсын хөгжилд өнгөрсөн 30 жилд хамгийн их эерэг нөлөө үзүүлсэн хүчин зүйлс бол ардчилал, эрх чөлөө, мэдээллийн технологи, хотын соёл, олон улсын харилцаа, барууны соёл, боловсрол болон нүүдлийн соёл ажээ.
- Монгол улсын хөгжилд өнгөрсөн 30 жилд хамгийн их сөрөг нөлөө үзүүлсэн хүчин зүйлс бол авлига, тэгш бус байдал, ядуурал, газрын доройтол, санхүүгийн алдагдал гэж гарлаа.

МОНГОЛ УЛСЫН ӨНГӨРСӨН 30 ЖИЛИЙН ХӨГЖИЛД ХАМГИЙН ИХ ЭЕРЭГ НӨЛӨӨ ҮЗҮҮЛСЭН ХҮЧИН ЗҮЙЛ

Ардчилал ба хүний эрх чөлөө бол Монгол улсын хөгжилд өнгөрсөн 30 жилийн түүхэнд хамгийн эерэг нөлөөтэй хүчин зүйл гэж гарсан нь үгүйсгэхийн аргагүй үнэн. Ардчилал болон хүний эрх чөлөө 2 нэг зоосны 2 тал гэлтэй. Монгол улс дэлхийд нээлттэй болсон нь хөгжлийн

хаалга боломжийг Монгол улсад болон монгол хүн бүрт цэлийтэл нээж өгсөн.

Мэдээллийн технологи бол даяаршлын үр дагавар гэж болох ч, Монгол улс нээлттэй болсон явдал мэдээллийн технологийн хөгжилд эерэг нөлөө үзүүлсэн нь дамжиггүй. ►►

- Системийн онолын үүднээс авч үзвэл, Монгол улс дэлхийд нээлттэй болсноор хөгжлийн зайлшгүй нөхцөл бүрджээ. Харин хөгжлийн хүрэлцээтэй нөхцөл болох хурдасгууруудыг бодлогоор хөхиүлэн дэмжих төрийн бодлогоо цаашид төгөлдөржүүлэх хэрэгтэй.

Хотын соёл, барууны соёл болон нүүдлийн соёл зэрэг хүчин зүйлүүдийг багцаар нь авч үзэж болно. Хотын соёлын асуудал хотожсон монголчуудын хувь заяанд нөлөөлөх хүчин зүйл мөн билээ. Монгол улс нээлттэй болсноор барууны соёл давамгайлах соёл болж буйг хүлээн зөвшөөрч, хүн төрөлхтний соёл иргэншлийн тэргүүний бүхнийг нутагшуулахаас өөр замгүй. Мөн нүүдлийн соёл ба түүх ардчиллаас хойш сэргэж, хөгжлийн эерэг хөшүүрэг болж байгааг нэгдсэн үнэлгээ харууллаа.

МОНГОЛ УЛСЫН ӨНГӨРСӨН 30 ЖИЛИЙН ХӨГЖИЛД ХАМГИЙН ИХ СӨРӨГ НӨЛӨӨ ҮЗҮҮЛСЭН ХҮЧИН ЗҮЙЛ

Авлига ба хээл хахууль Монгол улсын хөгжлийг хамгийн их хойш чангаагч хүчин зүйлээр тодорсон нь иргэдийн саналтай дүйж байна. Авлигын индексээр 2018 оны байдлаар 180 орноос 93-т буюу дундаас доогуур яваа нь ч үүнийг батална.

Тэгш бус байдал, ядуурал, газрын доройтол болон санхүүгийн алдагдал нь Монгол улсыг системээр нь хойш чангааж буй хүчин зүйлүүд аж. Ядуурал бол тэгш бус байдлын үр дагавар гэж үзэж болно. Газрын доройтолд хүний үйл ажиллагаа илүү нөлөөлж байгаа ч, уур амьсгалын өөрчлөлт “гэтэн ирж яваа аюул” тул энэ 2 хүчин зүйл хавсарч байгаа газрын менежментийг юуны өмнө сайжруулах шаардлагатай. Санхүүгийн алдагдал болон өр хоёр холбоотой. Хойч үедээ өрийн дарамт үлдээхгүй байх нь тогтвортой хөгжлийн нэг үндсэн зарчим юм.

Ардчилал, хувийн эрх чөлөөний гол амжилтаасаа ухрах яриа мэр сэр дуулах боллоо. 1990 онд өмнөх амжилтаа бататгах талаар алдаа гаргасан. Тухайлбал, түүхий эд боловсруулдаг үндэсний үйлдвэрүүдээ нураасан нь туйлын харамсалтай. Тэгвэл өнгөрсөн 30 жилийн амжилтуудаас ухрах аваас 1990 оны алдааг давтахын агаар нэгэн бус уу. Харин орчин үеийн технологи бүхий түүхий эд боловсруулдаг үйлдвэрүүд барьж байгуулан, 1990 оны алдаагаа даруй засч эдийн засгаа олон төрөл болгох хэрэгтэй. Барууны, хотын болон нүүдлийн соёлыг эзэмшүүлэхэд мэдээллийн технологи, хэвлэл, мэдээллийн хэрэгслийг өргөнөөр ашиглаасай. Хот хөдөөгийн сургуульд орчин үеийн төдийгүй монголын уламжлалт мэдлэгийг хослуулсан чанартай боловсролыг олгоход зайнаас сургах технологийг хангалтгүй ашигласан хэвээр байна.

Авлига, ядуурал, газрын доройтол болон санхүүгийн алдагдлын тухай олон жил ярьж байгаа ч дорвитой үр

Монголчуудын үнэт зүйлс болох нэг нутаг усныхнаа орчин үеийн сэргээгдэх эрчим хүч, мэдээлэл, блокчейн зэрэг технологиор сэргээн тогтвортой хөгжүүлэх цаг нь иржээ. Соёлын хүчин зүйлийг нэгтгэн дүгнэвээс, харийн болон үндэсний соёлын дэвшилттэйг хөхиүлэх, саарыг дарах төрийн бодлого улам бүр хэрэгтэй болсныг харууллаа.

Олон улсын харилцаа улам цэцэглэсээр Монгол улсын хөгжлийн гол хүчин зүйлийн нэг болжээ. Боловсрол бол хөгжлийн түлхүүр хурдасгуур билээ. Өрнөдийн хөгжсөн орнуудад сурч боловсорсон шинэ үеийнхэнтэй боллоо. Харин Монгол улс олон улсын харилцаа болон боловсролын энэ эерэг хүчин зүйлүүдийг оновчтой ашиглах төрийн бодлогоо төгөлдөржүүлэх нь зүйтэй.

дүн гарсангүй. Сүүлийн үед мөн тэгш бус байдлын талаар ихээхэн хэлэлцэх боллоо. Тэгш бус байдлыг арилгах нь авлигаар баяжих болон ядуурал аль алийг нь хамарч буй тул илүү системийн шинжтэй. Иймээс нийгмийн тэгш байдлаар дэлхийд манлайлагч улсуудаас суралцах хэрэгтэй юм.

Аливаа эерэг буцах холбоо буюу хурдасгуурууд бүхий нээлттэй тогтолцоонд аяндаа цэгцрэх хөдөлгөөн өрнөж болдог. Харин нийгмийн тогтолцоонд бол засаглал, хууль дүрэм журам л цэгцрэх буюу төгөлдөрших чиг рүү залдаг. Иймээс үндсэн хуулиа өөрчлөн, урт хугацааны хөгжлийн бодлогоо тодорхойлж, өнгөрсөн 30 жилийн амжилтуудаа улам бэхжүүлж, алдаагаа засч залруулахаар чармайж байна.

Монгол улсын Үндсэн Хуулийн шинэчлэл өнгөрсөн 30 жилийн ололтыг бататгаж, алдааг засах төдийгүй ирэх 30 жилийн хөгжлийн түүхээ болоосой! Урт хугацааны бодлого боловсруулахтай холбогдуулан, ирээдүйн 30 жилийн хөгжлийн талаарх өөрийн санаа бодлоо дараа өгүүлнэ.

Монгол улс 1990 онд дэлхийд нээлттэй болсноор хөгжлийн зайлшгүй нөхцөл бүрдсэн. Харин хөгжлийн хүрэлцээтэй нөхцөл болох хүний хүчин зүйл, боловсрол, шинжлэх ухаан, технологи, инновацийн хурдасгууруудыг дэмжин, харийн болон үндэсний соёлын дэвшилттэйг хөхиүлж, саарыг даран, нүүдлийн соёл иргэншлийг орчин үеийн технологиор шинэчлэснээр Монгол улс сэргэн мандах болно.

2019 оны 8-р сар

1 Måns Nilsson, Dave Griggs and Martin Visbeck. 2016. Policy: Map the interactions between Sustainable Development Goals. | N A T U R E | V O L 5 3 4 | 1 6 J U N E 2 0 1 6, 320-322.



ДеФакто **ТОЙМ**

Ням гараг бүр VTV телевизээр 21 цагт гардаг Дефакто тоймын эмхэтгэл:
2019.08.11-ний дугаар

Долоо хоног бүрийн тойм, <http://jargaldefacto.com/category/12>

АМЕРИК, ОРОСЫН БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД НАРЫН АЙЛЧЛАЛ

Өнгөрсөн долоо хоногт Ерөнхийлөгч Х.Баттулга АНУ-д айлчлаад ирсэн. Харин энэ долоо хоногт АНУ-ын батлан хамгаалахын сайд манай улсад айлчиллаа. Мөн ОХУ-ын батлан хамгаалахын орлогч сайд айлчилсан. Том хэмжээний айлчлалууд дараалан болж байгаа нь анхаарал татаж байна.

АНУ-ын батлан хамгаалахын сайдын айлчлалын гол ач холбогдол юу вэ. Сарын өмнө АНУ-ын Ерөнхийлөгчийн аюулгүй байдлын зөвлөх Жон Болтон ирсэн. Энэ 2 айлчлалд ямар хамаарал байна вэ?

Энэ хоёр айлчлал тохиолдлын байдлаар болоогүй нь мэдээж. АНУ-ын Батлан хамгаалахын сайд Др.Марк Т.Эспэрийн айлчлал урьдчилан мэдэгдсэн нь бага байлаа.

Др.Марк Т.Эспэр нь 1964 онд төрсөн, АНУ-ын Цэргийн академийг ерөнхий цэргийн офицероор төгссөн бөгөөд 1990-1991 онд Персийн булангийн дайнд оролцож явсан. Тэрбээр 2019 оны 7-р сарын 23-ны өдөр тангараг өргөснөөр АНУ-ын 27 дахь Батлан хамгаалахын сайд болсон. Түүний гадагшаа хийж байгаа анхны айлчлалын хүрээнд Монгол улс багтсан нь энэ.

УИХ, Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Н.Энхболдтой АНУ-ын Батлан хамгаалахын сайд Др.Марк Т.Эспэр уулзсан. Ноён Др.Марк Т.Эспэр тэргүүтэй АНУ-ын Батлан хамгаалах салбарын зочид Монгол Улсын Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний удирдлагуудтай уулзаж, хоёр орны Батлан хамгаалах салбарын харилцаа, хамтын ажиллагаа, цаашдын хөгжлийн чиг хандлагын талаар санал солилцсон.

Түүнчлэн Батлан хамгаалахын сайд Н.Энхболд ноён Др.Марк Т.Эспэрийг хүндэтгэж, түүнд адуу бэлэглэсэн. Энэ үеэр АНУ-ын Батлан хамгаалахын сайд Др.Марк Т.Эспэр хэлсэн үгэндээ "Манай хоёр орны батлан хамгаалах салбарын харилцаа нь талуудын нийтлэг эрх ашиг болох ардчилал, эрх чөлөө, хүний эрхийг дэлхий дахинд хамгаалах, хоёр орны ард түмний найрсаг харилцааг гүнзгийрүүлэх, бүс нутагт болон дэлхий дахинд цэргийн итгэлцлийг бэхжүүлэх, энх тайван,



тогтвортой байдлыг сахин хамгаалахад чухал үүрэг гүйцэтгэж ирсэн билээ. Цаашдаа ч энэ харилцаа улам батжиж, өргөжин хөгжинө гэдэгт эргэлзэхгүй байна" гэсэн юм. Тэрбээр ярианыхаа төгсгөлд "... Намайг хүндэтгэж морь бэлэглэсэнд би маш их баяртай байна. Энэ морийг манай улсын эрэлхэг генерал Жеорж Маршалын нэрээр нэрлэе. Учир нь тэрээр Дэлхийн II дайны дараа Хятад улсад цэргийн үйл ажиллагаанд оролцож байхдаа монгол адуу унаж байсан түүхтэй" гэсэн.

ОХУ-ын батлан хамгаалахын орлогч сайд мөн ирсэн. Орос Америкийн батлан хамгаалахын сайд нар дараалан ирж байгаад ямар шалтгаан байна вэ?

Хурандаа генерал А.В. Фомин нь ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путины 2017 оны 1-р сарын 31-ний өдрийн зарлигаар ОХУ-ын Батлан хамгаалахын орлогч сайд болсон.

Батлан хамгаалахын дэд сайд Т.Дуламдорж тэргүүтэй БХЯ, ЗХЖШ, төрийн цэргийн командлалуудын удирдлагуудтай ОХУ-ын Батлан хамгаалахын орлогч сайд, хурандаа генерал Александр Васильевич Фомин уулзсан. Уулзалтын үеэр манай улсад саяхан зохиогдсон "Аравт" олон улсын морин цэргийн анхдугаар уралдааны талаар ярилцаж, ОХУ-ын зүгээс манай улсын Зэвсэгт хүчнийг уг уралдааныг амжилттай зохион байгуулсанд талархаж байгаагаа илэрхийлсэн.

Хурандаа генерал А.В. Фомин хэлэхдээ "Аравт" олон улсын морин цэргийн анхдугаар



Оросын зарим мэдээллийн сайтад Америк Монголд пуужингаа байршуулж магадгүй гэсэн мэдээлэл гарсан байсан. Үндэслэлтэй юу?

Тийм мэдээлэл гарсан байна лээ. Ноён Др.Марк Т.Эспэр АНУ-ын батлан хамгаалахын сайд болмогцоо бид Орос, Хятадтай ойр газар дунд зайны цөмийн зэвсэг зөөгч пуужингуудаа байрлуулна гэж хэлсэн. Энэ мэдэгдлээс хойш "тэгээд аль орон юм бэ" гэдгийг орон бүр асууж байгаа. Яагаад гэвэл тэр орныг мэдмэгцээ Хятад, Оросын ялангуяа Орос пуужингаа тэр орон руу харвахаар бэлдэж тавина. Дунд зайны пуужин гэдэг нь 500-5000 км-ийн зайд буудаж чадах газарт байрлуулсан пуужин юм.

Орос Америк хоёр улс пуужингаа хорих гэрээтэй байсан. Тэр гэрээний үр дүнд маш олон пуужинг устгасан. Гэтэл Америкчууд Оросуудыг өөр нэртэйгээр пуужингаа цэргийнхээ хүчинд нийлүүлж байна гэж үзсэн. Ингээд өнгөрсөн оны 8-р сард Ерөнхийлөгч Трамп бид энэ гэрээнээсээ гарлаа гэж зарласан. Оросууд үүнийг үндэслэлгүй гэж үзсэн. Ийм нөхцөл байдалд ямар нэгэн үндэслэл хайн мэдээлэл гаргаж байгаа нь тэр.

Гэхдээ Монгол улс 1992 онд Цөмийн зэвсгээс ангид бүс болно гэж Засгийн газар нь тунхагласан. 2000 онд УИХ-ын тогтоол гарч албан ёсоор баталсан. Монголын нутаг дэвсгэр тухайлбал газар, ус, агаараар цөмийн зэвсэг зөөвөрлөх болон байрлуулахыг хориглоод зогсохгүй, цэрэг зэвсгээр хөөцөлдөхийг болих стратегийг батална гэж заасан. Тэгэхээр Монгол улсад цөмийн зэвсэг байрлуулах, зөөвөрлөх ямар нэгэн ажиллагаа болохгүй. Мөн манай улс хоёр цөмийн зэвсэгтэй том гүрний дунд байдаг учраас цөмийн зэвсэгт өртөхгүй байхыг баталгаажуулж өгөөчээ гэдгийг гадаад бодлогодоо гаргаад НҮБ-ын хэмжээнд дэмжигдээд явж байгаа. Тиймээс дээрх Оросын мэдээллийн сайтуудад гарсан мэдээлэл бол энэ бүхнийг мэдэхгүй хүмүүсийн л яриа юм. Үндэслэлгүй яриа гэсэн үг.

уралдааныг та бүхэн өндөр хэмжээнд зохион байгуулж чадлаа. Энэ бол олон жилийн түүхтэй хоёр орны Батлан хамгаалах салбарт түүхийн нэгэн шинэ хуудас нэмсэн үйл явдал юм" гэсэн. Батлан хамгаалахын дэд сайд Т.Дуламдорж "Манай улс "Армейские игры-2019"-ийн хүрээнд Танкийн биатлон, Мэргэн буудагчийн зааг, Инженерийн томьёолол, Хээрийн гал тогоо гэсэн төрлүүдэд оролцохоос гадна Таны хэлсэнчлэн "Аравт" олон улсын морин цэргийн анхдугаар уралдааныг эх орондоо амжилттай зохион байгууллаа. Энэхүү тэмцээний хаалтын ёслолын ажиллагаанд ОХУ-ын Батлан хамгаалахын орлогч сайд оролцохоор ирсэн нь хоёр орны Батлан хамгаалах салбарын хамтын ажиллагаанд ОХУ өндөр ач холбогдол өгч буйн илрэл гэж харж байна" гэж онцлон тэмдэглэсэн.

АНУ-ын батлан хамгаалах үйл ажиллагааны хамгийн гол зорилго нь 13 жилийн турш Исламын улс бүлэглэлтэй тэмцэж, хамгаална гэдэг байсан бол өнгөрсөн жилээс эхлэн Хятад, Орос улсаас өөрсдийгөө хамгаална гэсэн шинэ зүйл оруулсан. Мөн Монгол, Америк хоёр улс цэргийн стратегийн түнш. Монгол цэргүүд энхийг сахиулах ажиллагаанд оролцдог болоод удаж байгаа. Мөн Хойд Солонгостой галт тэргээр шууд холбоотой, хоёр Солонгостой дипломат харилцаатай орон бол Монгол юм.

Та "Дефакто Газет" цахим сонинг тогтмол хүлээн авахыг хүсвэл

www.jargaldefacto.com болон www.defacto.mn вебсайтад өөрийн имейлээ бүртгүүлнэ

РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛ

Ерөнхий эрхлэгч:
Дамбадаржаагийн Жаргалсайхан

Ерөнхий Редактор:
Ганбаатарын Жавзмаа

ГҮЙЦЭТГЭЛИЙН БАГ

Отгонсүрэнгийн Билгүүн
Адъяагийн Тунгалаг

ХОЛБОО БАРИХ


✉ editor1@jargaldefacto.com

☎ +976 94109342

🌐 www.defacto.mn

www.jargaldefacto.com

ХӨДӨЛГҮҮРИЙН МӨНХИЙН ҮС



**TOTAL QUARTZ 9000
5W-40**



**ДОКТОР АВТО СҮЛЖЭЭ
ДЭЛГҮҮРИЙН БҮХ САЛБАРААР
ХУДАЛДААЛАГДАЖ ЭХЭЛЛЭЭ.**

Холбоо барих утас: 9411-7143, 9906-6402



www.minesup.mn



@TOTALMongolia



fb.com/TOTALMongolia



@TOTALMongolia

Албан Ёсны Дистрибьютор:

UP
MINES
www.minesup.mn